



## ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

2021 оны санхүүгийн тайланд өгсөн Аудитын зөвлөмжийн биелэлтийг ерөнхий нягтлан бодогч Ж.Даш танилцуулав.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

.... “2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн 1 акт, 1 залруулга, 3 албан шаардлагын биелэлттэй танилцав. Биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/270 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.”...гэж тэмдэглэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Санхүүгийн тайлан балансад зөрчлийг давтан гаргахгүй байх цаашид нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/, Ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/-нарт үүрэг болгосугай”...гэжээ.

ДАРГА  П.ДАВААДОРЖ

ДАРХАН-УЛААМАГ ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ  
ТТ08536 № 474/036



## ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэг, Компанийн дурмийн 7.3.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 409 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн а/4042 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд хийгдсэн, төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн 107 576 610 /нэг зуун долоон сая таван зуун далан зургаан мянга зургаан зуун арван/ төгрөгийн үнэ бүхий хөрөнгүүдийг бүртгэлд тусгахыг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.
2. Компанийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтын дор үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/-нарт үүрэг болгосугай.
3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 409 дүгээр тогтоолын хавсралтад дурьдсан “Шинэ Орчин” 72 айлын орон сууцнаас 32 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний 141 491 840 төгрөгийн ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А-1/424 дүгээр тогтоолоор 2021 оны эхний хагас жилд бүртгэлд тусгасан талаар албан бичгээр хандаж, залруулж авахыг ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/-д даалгасугай.



ДАРГА

П.ДАВААДОРЖ



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 10 дугаар сарын 26-ны  
өдрийн 18 дугаар тогтоолын хавсралт

### ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Хөрөнгийн нэр	Он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ, хүчин чадал	Дүн	Санхүүжилтийн эх үүсвэр
1	42-47 дугаар худгийг шугамын шинэчлэл	2020	метр	130м /5хос/	43 338 088	Багатаян ХХК
2	Ус түгээх 8-р худаг	2020	ш	1	21 500 000	Хатан түшиг трейд ХХК
3	Гэр хорооллын Ойчдын 17-р гудамжинд төвлөрсөн ус хангамжийн шугам	2018	метр	1200	42 738 522	Шарын гол ХК
ДҮН					107 576 610	